



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/465

Арвайхээр

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 10.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 12/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 6 нэгж талбарын газрын анхны үнэ, хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг дахин цахим хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсугай.

3. Дуудлага худалдаа явуулах зар мэдээг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээн авч дуудлага худалдааг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

011100985

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны ...⁰⁹
 дугаар сарын ...²⁹...-ны өдрийн ...^{А.М.}... дугаар
 захирамжийн хавсралт



АРВАЙХЭЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ
 БҮХИЙ ГАЗАРТ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА
 ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ, ГАЗРЫН БАЙРШИЛ,
 ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөлт ийн нэгж талбарын дугаар	Газар эзэмшүүлэх Зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м2/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ (мян.төг)
1.	Онги 13 дугаар баг, шинэ Арвайхээр төв	2266835	5-8 давхар нийтийн орон сууц	4335	15606,0
2.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2252604	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	7276	17462,4
3.	Онги 13 дугаар баг, шинэ Арвайхээр төв	2252606	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	1403	5050,3
4.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264134	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0
5.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264135	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0
6.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264136	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0

